



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот


Итгэлцүүр тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Даатгуулагч нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгоход 2024 онд хэрэглэх итгэлцүүрийг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2011 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заасан сарын дүнг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, мөн өдрөөс хойш 2023 оныг дуустал хугацаанд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд албан журмын даатгуулагчийн хувьд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тус тус тооцсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 238 дугаар тогтоолын 3 дугаар заалтыг хүчингүй болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр
сарын 10-ны өдрийн 10 дугаар
тогтоолын хавсралт

ДААТГУУЛАГЧ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХОД 2024 ОНД
ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Он	Итгэлцүүр
1990 он ба түүнээс өмнөх он	2060.74
1991	1031.18
1992	526.20
1993	215.16
1994	130.16
1995	49.74
1996	37.79
1997	31.86
1998	25.35
1999	22.09
2000	17.05
2001	16.21
2002	14.99
2003	13.30
2004	11.71
2005	10.75
2006	8.80
2007	6.68
2008	4.49
2009	4.16
2010	3.66
2011	3.06
2012	2.44
2013	1.83
2014	1.65
2015	1.62
2016	1.60
2017	1.50
2018	1.39
2019	1.32
2020	1.23
2021	1.13
2022	1.00